

## **ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Төрийн нууцын тухай хуулийн төслийн 19 дүгээр зүйлд төрийн нууцтай танилцах ажил, албан тушаалд аюулгүй байдлын шалгалтын дүнг үндэслэн тодорхой зэрэглэлийн нууцтай танилцах эрх олгосон иргэнийг ажиллуулах бөгөөд хяналт шалгалт, аудитын болон тодорхой ажил, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн нууцтай танилцах иргэн, албан тушаалтанд энэхүү шаардлага нэгэн адил хамаарахаар тусгасан.

Төрийн аудитын тухай хуулийн 6.4-т “Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурлын даргаас итгэмжилсэн аудитор аудит хийх бөгөөд уг аудитыг гүйцэтгэх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална” гэж заасан боловч Улсын Их Хурлын даргаас итгэмжлэл олгохоос өмнө тухайн аудитор нь төрийн нууцтай танилцах шаардлага, нөхцөлийг хангасан эсэх, түүнд тавих шаардлага зэргийг хуульчлаагүй байна.

Иймд Төрийн нууцын тухай хуулийн төсөлтэй уялдуулан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн төсөлд гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийх итгэмжилсэн аудитор нь төрийн нууцтай танилцах эрх олгогдсон байхаас гадна дараах шаардлагыг хангасан байхаар тусгалаа. Үүнд:

- 1.төрийн аудитын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;
- 2.мэргэшсэн нягтлан бодогч байх;
- 3.ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх;
- 4.тухайн байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй байх.

Мөн Улсын Их Хурлын даргаас тухайн аудиторт итгэмжлэл олгохдоо хуульд заасан эрхлэх асуудал, хариуцсан чир үүргийн хүрээнд Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороонд урьдчилан танилцуулдаг байхаар, мөн гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийх журмыг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо баталдаг байхаар тус тус нарийвчлан зохицууллаа.